



LAVAI-INTERNATIONAL JOURNAL OF EDUCATION

2022 №26, ISSN 2410-4507

Веб сайт: <https://lavai.msue.edu.mn>

Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн чанарын судалгаа

Батсайхан Жавзандулам*

Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Арга зүйн тэнхим

*Холбоо барих зохиогч: javzandulam@msue.edu.mn

Хүлээн авсан: 2022.4.25

Засварласан: 2022.6.28

Хэвлэлтэд авсан 2022.6.30

Хураангуй

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг 2015 онд боловсруулахдаа цэцэрлэгийн үзэл баримтлал, хүүхдийн хүсэл сонирхол, сонголтод тулгуурласан тоглонгоо суралцах өдөр тутмын үйл ажиллагаа, хүүхэд бүрийн хөгжлийн ахицын үнэлгээ зэрэг онол, арга зүйн хувьд өмнөх сургалтын хөтөлбөрөөс олон талаараа шинэчлэгдэн, өөрчлөгдсөн байдаг бөгөөд эдгээр нь хөгжингүй улс орны сургуулийн өмнөх боловсролд түгээмэл хэрэгждэг онол арга зүйн чиг хандлага юм. Цөм хөтөлбөр 2015 боловсруулсан үйл явцын онцлогийг судлахын тулд өмнөх хөтөлбөрүүдтэй харьцуулсан баримт бичгийн шинжилгээ хийн, хөтөлбөрийг боловсруулахад оролцсон багш, судлаач нараас (n=8) ярилцлага авч чанарын судалгааны аргаар үр дүнд боловсруулалт хийв. Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэл хийгдэх хэрэгцээ шаардлагатайг төрийн болон боловсролын байгууллагын багш, судлаач нар анх тодорхойлсон байдаг. Судалгааны үр дүнд сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг тухайн үед шинэчлэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд: (1) тухайн үеийн эрх баригчид боловсролын бодлогын шинэчлэлийг бүх шатанд эрчимтэй зохион байгуулсан, (2) Хөтөлбөрийг боловсруулсан багийнхан хөгжингүй улс орны хөтөлбөрийн хэрэгжилтийг газар дээр нь очиж танилцаж, судалсан туршлагатай байсан, (3) Сургуулийн өмнөх боловсролын багш нар хөтөлбөрийн шинэчлэл хийх шаардлагатай байгааг илэрхийлж байсан, (4) Эцэст нь, тухайн үеийн шийдвэр гаргагчид хүүхэд бүрийн хөгжилд тоглох үйлийн ач холбогдлын тухай сайн мэдлэгтэй байсан.

Түлхүүр үг

Сургуулийн өмнөх боловсрол, хөтөлбөрийн шинэчлэл, тоглонгоо суралцах арга зүй



This article is published under the
Creative Commons CC-BY License by 4.0

©2022 Author

Удиртгал

Дэлхийн олон улс орон бага насны хүүхдийн хөгжилд тоглох үйлийн үзүүлэх эерэг нөлөөг олон талаас нь авч судалсан судалгааны үр дүнд үндэслэн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрөө тоглонгоо суралцах арга хандлагаар шинэчлэх болсон. Монгол улс 2015 онд сургуулийн өмнөх боловсролын (СӨБ) хөтөлбөрөө шинэчилж, хүүхдийн хүсэл сонирхлыг харгалзсан, тэдний сонголтод үндэслэсэн тоглонгоо суралцах үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрт тусгаж оруулж ирсэн. Мөн Монгол улс сургуулийн өмнөх боловсролдоо ач холбогдол өгдөг гэдгийг улсын төсвийн зарцуулалтаас харж болно. Тухайлбал, дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувь буюу боловсролын салбарын нийт төсвийн 24 хувийг сургуулийн өмнөх боловсролд зарцуулдаг гэсэн тоо баримт бий (World Bank, 2017, p.17). Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж бусад улс оронтой харьцуулбал харьцангуй өндөр буюу 83.3 хувьтай байна. Сүүлийн жилүүдэд хувийн цэцэрлэгийн тоо (948 цэцэрлэг) эрчимтэй өсөж байгаа боловч улсын цэцэрлэг (1454 цэцэрлэг) салбартаа гол ачааллыг авч байгаа хэвээр байна (БШУЯ, 2021). Энэхүү судалгаагаар 2015 оны монгол улсын сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн үндэслэл, боловсруулсан үйл явцыг чанарын судалгааны аргаар шинжлэн судлав. Хөтөлбөрийг шинэчлэхэд нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлсон хэд хэдэн судалгаа хийгдсэн байдаг (Datnow, 2002, p.215; Ijaduola et al, 2012, 125; Rao & Tse, 2012, p.612). Тухайлбал, Ijaduola et al. (2012, p.125) хийсэн судалгаандаа хөтөлбөрийг өөрчлөхөд хүргэдэг дараах хүчин зүйлсийг тодорхойлсон. Үүнд: (а) тухайн салбарын мэргэжлийн хүмүүс болон олон нийтийн оролцоо, (б) тухайн хөтөлбөрийн үзэл баримтлалын хүрээнд тавьсан алсын хараа, хэтийн зорилго, (в) гадаад хүчин зүйл буюу олон улсын хэмжээнд нэгдсэн бодлого, (г) хөтөлбөрийн шинэчлэлд уриалсан салбарын мэргэжлийн хүмүүсийн бүтээлч санаачилга зэрэг хүчин зүйлс байдаг хэмээн тодорхойлсон. Үүнээс гадна сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд өөр нэг зайлшгүй нөлөөлдөг хүчин зүйл бол тухайн улс орны улс төрийн нөхцөл байдал юм (Ijaduola et al, 2012, p.125). Энэ нь боловсролын хөтөлбөрт үнэлгээ хийх, шинэчлэл хийхэд нөлөөлдөг гэж Kasuga (2019, p.29) тодорхойлсон бол Li, Wang & Wong (2012, p.10) хөтөлбөрийн шинэчлэл нь тухайн улс орны соёлын хам хүрээнд хэр нийцсэн байх нь тухайн хөтөлбөр амжилттай хэрэгжих чухал хүчин зүйл гэж үзсэн бөгөөд хэл соёл, багш, эцэг эх, сургалтын орчин, боловсролын тогтолцоо зэрэг нь хөтөлбөрийн шинэчлэлийн тулгуур багана хэмээн тодорхойлжээ. Vavrus & Bartlett (2012, p.638) нар хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцыг амжилттай өрнүүлэхэд соёл, улс төр, нийгэм эдийн засгийн нөхцөлийг онцолсон байхад Datnow (2002, p.215) сургалтын зохион байгуулалт, нөөц бололцоо, суралцагчийн ялгаатай байдал, сургалтын үр дүн, багшийн итгэл үнэмшил зэргийг гол хүчин зүйлс хэмээн тодорхойлсон. Дээрх судалгаанууд хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд тодорхой үр дүнг харуулсан боловч ихэнх нь бага дунд боловсролын түвшинд хийгдсэн

байна. Үүнээс үзэхэд, сургуулийн өмнөх боловсролын түвшинд хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой судалгаа монгол улсад төдийгүй олон улсад харьцангуй цөөхөн хийгдсэн байгаа нь харагдаж байна. Энэхүү судалгааны зорилго нь монгол улсад 2015 онд сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэл хийгдэх болсон үндэслэл, нөхцөл байдал, үйл явцыг чанарын судалгааны аргаар шинжлэн судлахад оршино.

Судалгааны арга зүй

Бид судалгааны ярилцлагыг 2021 оны 6-р сард зохион байгуулсан бөгөөд 6-р болон 7-р сард бичиг баримтад боловсруулалт хийх сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрүүдийг харьцуулсан судалж, ярилцлагын дата мэдээлэл дээр чанарын судалгааны аргаар боловсруулалт хийсэн. Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрүүдийг харьцуулан судалж, урьдчилан бэлтгэсэн хагас бүтэцтэй ярилцлагын удирдамжийн дагуу 2013-2015 онд хөтөлбөр боловсруулах багт ажилласан 16 гишүүний 8 хүнээс ярилцлага авсан. Ярилцлага өгсөн оролцогчид хөтөлбөрийн шинэчлэлд гар бие оролцсон хөтөлбөрийн багийн үндсэн гишүүд байсан бөгөөд сургуулийн өмнөх боловсролын салбарт өөр өөр албан тушаалтай хүмүүс бөгөөд хөтөлбөр боловсруулахаас өмнө тэдгээрийн дөрөв нь Япон, ХБНГУ, БНХАУ Гонконг, Өмнөд Солонгос болон ОХУ зэрэг улсад

Table 1

Characteristics of Preschool Education Core Curriculum in Mongolia in Comparison with Previous Ones

	Өмнөх хөтөлбөр (1986, 1991, 1999, 2013)	СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр (2015)
Хөтөлбөрийн төрөл	Мэдлэгт суурилсан хөтөлбөр (1986, 1991, 1999) Стандартад суурилсан хөтөлбөр (2013) *	Тоглох үйлд суурилсан хөтөлбөр, Чадамж суурилсан хөтөлбөр, Хүүхэд төвтэй хөтөлбөр
Хөтөлбөрийн зорилго	“Бага насны хүүхдийн хэрэгцээнд тулгуурласан хүртээмжтэй, чанартай, үр ашигтай, цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжиж, тэднийг сургуульд амжилттай бэлтгэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино” (2012, ху.25).	“Хүүхэд бүрийн бие, сэтгэлээр эрүүл өсг бойжуулахад багш, судлаач, эцэг эх хамт ажиллахад дэмжлэг үзүүлж, хүүхэд 6 өөрийн онцлог бүтээлч үйлээрээ хөгж боломж олгоход оршино” (ху.17).
Цэцэрлэгийн зорилго	Цэцэрлэгийн үйл ажиллагаа гол төлөв багшаар удирдуулсан байх ба үлгэр, дуу, шүлэг гэх мэт сургалтын сэдэв болон агуулгыг долоо хоногт хэдэн удаа хэдий хугацаанд зохион байгуулахыг тодорхой заасан.	Цэцэрлэг бүр үзэл баримтлалаа тодорхойл эрх чөлөөтэй. Үзэл баримтлал дээр үндэслэн суралцах, багшлах ү ажиллагаагаа цөм хөтөлбөрт заас зөвлөмжийн дагуу төлөвлөх эрх чөлөөтэй.
Суралцах үйл	Суралцах үндсэн хэсгийг “хичээл” гэж нэрлэдэг. Хичээлийн чиглэл биеийн тамир, эрүүл мэнд, математик, хэл яриа, дүрслэх урлаг, хөгжим, харилцаа.	“Чадамж” гэдэг нь “мэдлэг, чадв төлөвшилийн цогц үзүүлэлт” юм. Хөдөлгө эрүүл мэндийн, нийгэмшихүйн, хэл яриаг орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилц математикийн, дүрслэх урлагийн зэ чадамж бий.
Үнэлгээ	Хүүхдийн хөгжлийг хяналтын хуудсын дагуу тоон мэдээлэлд үндэслэн хөндлөнгийн үнэлгээ хийдэг.	Багш өдөр тутмын ажиглалт, хувийн хөгжлийн хавтсанд цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн хүүхэд бүрийн хөгжлийн ахицыг чанарын аргаар үнэлдэг.

(Тэмдэглэл) * 2011 оны бага насны хүүхдийн хөгжлийн стандартад үндэслэн стандартад суурилсан хөтөлбөр 2012 онд боловсруулсан. (Эх сурвалж) БНМАУ-ын Ардын Боловсролын Яам Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэн. (1986). *Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүмүүжил сургалтын программ*. Нэмэлт өөрчлөлт оруулсан хоёр дахь хэвлэл. Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар; БНМАУ-ын боловсролын яам. (1991). *Хүүхдийн цэцэрлэгийн хүмүүжил сургалтын хөтөлбөр*. Шинэчлэн боловсруулсан 2 дахь хэвлэл. Боловсролын яамны сурах бичиг. Хүүхдийн номын хэвлэлийн газар, Гэгээрлийн яам; УБИС-ийн Боловсролын хөгжлийн сургууль (1999). *Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын цөм хөтөлбөр*. Улаанбаатар хот; Мягмар.Ж ба бусад. (2013) *Сургуулийн өмнөх боловсролын бага бүлгийн сургалтын хөтөлбөр*. Боловсрол шинжлэх ухааны яам. Улаанбаатар: Admarket ХХК; Стандартчилал хэмжил зүйн газар. (2011). *Монгол улсын стандарт. Сургуулийн өмнөх боловсрол. Бага насны хүүхдийн хөгжлийн*; Насанбаяр. Б, Норжхорлоо. Н, Нарантуяа. Ж. (2015). *Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр гарын авлага*. Боловсрол шинжлэх ухааны яам.

мэргэжил дээшлүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагаар танилцаж, ажилласан байсан. Нийт ярилцлагын хугацаа 6 цаг 35 минут үргэлжилсэн. Монгол хэл дээр явагдсан ярилцлагыг аудио бичлэгийг Чимэгэ системс-ийн программаар компьютерт шивж оруулан англи хэл рүү орчуулсан. Англи хэл дээр сэдэвчилсэн чанарын анализ хийсэн нийт үгийн тоо 28.956. Судалгааны үр дүнгийн хэсэгт, оролцогчдыг “O1-O8” гэж тэмдэглэсэн. Англи хэл дээр боловсруулсан судалгааны үр дүнг монгол хэл рүү орчуулсан.

Судалгааны үр дүн ба хэлэлцүүлэг

Судалгааны эхний хэсэгт өмнө нь хэрэгжиж байсан сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрүүдийг 2015 оны хөтөлбөртэй харьцуулан, онцлог ялгаатай шинж чанарыг тодорхойлсон (Хүснэгт 1). Хөтөлбөрийн зорилгын хувьд өмнөх хөтөлбөрүүдийн хүүхдэд гол төлөв мэдлэг олгох зорилготой байсан бол 2015 оны цөм хөтөлбөр тоглох үйлээр дамжуулан хүүхэд бүрийн цогц хөгжлийг дэмжих зорилготой байна. Үүнийгээ дагаад багшийн үүрэг оролцоо, сургалтын арга зүй, үнэлгээний аргачлал өөрчлөгдсөн. Өмнөх сургалтын хөтөлбөрт заасан хичээл үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг дагахаас илүү хүүхэд бүрийн хүсэл сонирхол, хөгжлийн хэрэгцээнд нийцсэн өдөр тутмын үйл ажиллагааг багш төлөвлөж, зохион байгуулахад чиглэж ажиллах болсон (Насанбаяр, Норжхорлоо, Нарантуяа, 2015, х.11). Тоон мэдээлэл дээр үндэслэн үнэлгээ хийхээс илүүтэй багш үйл ажиллагааны явцад хүүхдийг ажиглаж тэмдэглэл хөтлөн, хүүхдийн хөгжлийн хувийн хавтасд мэдээлэл цуглуулан хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг тодорхойлох, баримт мэдээлэлд цуглуулан, тэдний хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулах болсон.

Манай судалгаанд оролцсон хөтөлбөрийн шинэчлэлийн багийн гишүүн бөгөөд өмнө нь их сургуульд багшилж байсан туршлагатай, боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд (БСШУЯ) олон жил ажилласан ОЗ оролцогч анх сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэх санаачилга гаргасан байна. Тэрээр багийн бусад хоёр гишүүний хамт тухайн үеийн БСШУЯ-ны сургуулийн өмнөх боловсролын салбарыг хариуцсан албан хаагчидтай хөтөлбөрийн шинэчлэлийн хэрэгцээ шаардлагын тухай уулзаж ярилцсанаар 2012 онд сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах үйл явц эхэлсэн. Хөдөлбөрийн баг хамгийн анх ХБНГУ, Финланд, Япон, Канад, Сингапур болон ОХУ зэрэг улс орны сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг харьцуулан судалсан судалгааны тайланг гаргасан байдаг (Норжхорлоо, Бурмаа, Гэрэлтуяа, Наран, Төмөр-Очир, 2014, х. 60). Хэдийгээр олон улсын төрийн бус байгууллагууд сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэлд чухал хувь нэмэр оруулдаг боловч 2015 оны сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцад идэвхтэй оролцохоос илүү тухайн үеийн БСШУЯ өөрөө санаачлан, гардан зохион байгуулсан байдаг.

Table 2-т бага насны хүүхдийн хүсэл сонирхол, сонголтод суурилсан

тоглонгоо суралцах арга зүйг нэвтрүүлсэн сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийг анх хэрэгжүүлэх болсон үндэслэл, үйл явцын тухай хийсэн ярилцлагын анхан шатны мэдээлэлд чанарын шинжилгээний аргачлалаар гарч ирсэн үндсэн сэдвийг харуулсан байна. Кодлох нь чанарын судалгааны арга зүйн үндсэн хэсэг бөгөөд үргэлжилсэн үгээр бичигдсэн баримт мэдээлэлд тодорхой сэдвийн хүрээнд шошго үүсгэн ангилан шинжлэх үйл явц юм (Saldaca, 2016, p.14). Код бүрийг тодорхой сэдвийн хүрээнд ангилахыг категори гэнэ (Creswell & Poth, 2016, p.84). Ярилцлагын мэдээллээс нийт 4 категори бүхий 9 код гарч байна. Эхний код бол улс төрийн өөрчлөлтөөс хойш бүх шатны сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийсний нэг нь сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөр байв. Үүнээс өмнө сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр бага насны хүүхдийг сургуульд бэлтгэхэд чиглэсэн байсан бол 2015 оны хөтөлбөр нь хүүхдийн насан туршийн суралцах чадамжид суурилсан ба хүүхдийн сонголтыг сургалтад оруулж ирснээрээ шинэлэг байсан. Хоёрдугаар кодын хувьд, сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэл нь тухайн боловсруулсан багийн хийсэн судалгааны үр дүн болон онолын судалгаа дээр үндэслэн явагдсан. Тухайлбал, оролцогч О3 дэлхий дахинд хувьсан өөрчлөгдөж байгаа нийгмийн хэрэгцээний улмаас хүний чадамжийн хөгжлийг онцолж авч үзэх болсон хэд хэдэн судалгааны үр дүнгийн тухай ярилцлагын явцад дурдсан. Мөн оролцогч О4 цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулагддаг олон төрлийн уралдаан тэмцээнээс илүү өдөр тутмын үйл ажиллагааг чанартай явуулах хөтөлбөр хэрэгтэй байсан тухай дэлгэрэнгүй ярилцсан. Гуравдугаар кодын хувьд, сургуулийн өмнөх боловсролын хүрээнд хүүхэд бүрийн хөгжлийг дэмжихэд тоглоомын үйл ажиллагаа ямар чухал болохыг судалгаанд оролцогчид онцлон тайлбарлаж байв. Оролцогч О3, бага насны хүүхэд дуртай тоглоомоороо тоглох нь тэдний танин мэдэх, суралцах үйлд олон талаар эерэг нөлөө үзүүлж байдаг. Хамгийн сүүлийн код нь цөм хөтөлбөрийг боловсруулахаасаа өмнө хөгжингүй улс орны сургуулийн өмнөх боловсролтой очиж үзэж танилцсан туршлага байв. О4 өөрийн туршлагаа ярихдаа манай улсын сургуулийн өмнөх боловсролын ихэнх үйл ажиллагаа зааж сургахад зарцуулдаг бол хөгжингүй улс орны сургуулийн өмнөх боловсрол илүү чөлөөтэй, хүүхэд тааваараа, сонирхлынхоо дагуу үйл ажиллагаанд оролцох явцад багш тохирсон дэмжлэг үзүүлэх байдлаар зохион байгуулагддаг. Мөн жил бүрийн олон уралдаан тэмцээнд багш нар өөрсдөө болон хүүхдүүдээ бэлдээд тун завгүй байх үе байдаг бол ХБНГУ-ын цэцэрлэгийн багш хүүхдүүд хамтдаа өөрсдийн хүсэл сонирхлоороо өдөр тутмын аливаа үйл ажиллагаагаа зохион байгуулж байгаа нь ажиглагдаж байсан.

Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийн шинэчлэлийг олон нийтэд зарлаж, шинэчлэлийн үйл ажиллагаанд орохоосоо өмнө хөтөлбөрийг боловсруулсан баг хүүхдийн хөгжлийн үнэлгээний шинэчлэл болон цэцэрлэгийн үзэл баримтлал дээр хэд хэдэн хэлэлцүүлэг өрнүүлж байсан. Учир нь эдгээр нь хүүхэд тоглонгоо суралцах үйл ажиллагааг дэмжсэн цэцэрлэгийн багш нарын

хувьд шинэ бүрдэл хэсэг байсан. Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийн шинэчлэлтэй хамт сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэх хөтөлбөрт мөн шинэчлэл хийж, “Тоглонгоо суралцахуй”, “Ажиглалт, үнэлгээ”, “Үйлийн судалгаа” зэрэг хичээлүүд оруулснаар цэцэрлэгт хүүхдийн суралцах орчин, багшийн үүрэг оролцоо, сургалтын арга зүй хамт шинэчлэгдсэн.

Table 2

Key Stakeholders' Accounts of Introducing a Play-based Curriculum in Mongolian Preschool Education

Код	Категори
Шинэчлэх эрх мэдэл	Улс төрийн өөрчлөлт
Боловсролын бодлогын шинэчлэл	
Чадамжийн хэрэгцээ	Судалгааны үр дүнд хийсэн эргэцүүлэл /тайлан, онол үзэл баримтлал
Үзэл баримтлал	
Хөгжлийн онол	
Хүүхдийн хөгжлийн онцлог	Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн тоглох үйлийн ач холбогдол
Хүүхэд бүрийн суралцах онцлог	
Сургалтын агуулга	Хөгжингүй улс орны СӨБ-ын талаарх ойлголт, туршлага
Цэцэрлэгийн дунд зохион байгуулагддаг уралдаан тэмцээн	

Үүний адил хөтөлбөрийн шинэчлэлийн багийнхан шинэ цөм хөтөлбөрийг цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд тулгарч болзошгүй бэрхшээлийн талаар урьдчилан тооцоолон хэлэлцсэн бөгөөд тэдгээр нь хүний нөөц болон материаллаг орчин гэж тооцоолж байв. Хүний нөөцийн хувьд хэдийгээр хүүхэд төвтэй сургалтын тухай өмнө нь нэлээдгүй сургалт явагдаж байсан боловч өдөр тутмын үйл ажиллагааны явцад хүүхдээ сонсох, ажиглах нь дутагдалтай байгаа нь энэ шинэчлэгдсэн хөтөлбөр хэрэгжихэд нэг том бэрхшээл болно гэж багийн гишүүд үзэж байсан гэж О8 хэлсэн. Үүнчлэн О1 ажиглалтын үнэлгээний аргачлалын хувьд үнэлгээ нь багшаас ихээхэн цаг хугацаа, анхаарал шаардагдаж удирдлага зохион байгуулалтаар хангах шаардлагатай байсан. О6-ийн хэлж байгаагаар хүүхдийн тоо ихтэй анги бүлгийн хувьд шинэчлэгдсэн үнэлгээний аргачлал тохиромжгүй байх магадлалтай гэж үзэж байсан. Харин материаллаг орчны хувьд тоглонгоо сурах таатай орчныг бүрдүүлэхэд тоглоомын хүрэлцээ нь асуудал болж байсан.

Ijaduola et al. (2012) хийсэн судалгаанд дурдсан таван хүчин зүйлс бүгд сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөрийг шинэчлэхэд нөлөөлжээ. Тэдгээрээс хөтөлбөрийн шинэчлэлд уриалсан мэргэжлийн хүмүүсийн бүтээлч санаачилга болон сургуулийн өмнөх боловсролын салбарын мэргэжлийн хүмүүсийн оролцоо монгол улсын нөхцөлд түлхүү нөлөөлсөн байна. Мөн үүний зэрэгцээ тухайн үеийн улс төрийн нөхцөл байдал буюу хөгжлийн бодлого

хөтөлбөр шинэчлэх үндэс нь болсон байна (Ijaduola et al, 2012, p.125).

Сургуулийн өмнөх боловсролын хэрэгжиж байсан хөтөлбөрүүдтэй харьцуулан судалж үзэхэд цөм хөтөлбөр нь олон талаараа хүүхдийг гол төвөө болгосон сургалтын арга зүйг хэрэгжүүлэх болсон. Тухайлбал, өмнөх хөтөлбөрт түлхүү хэрэглэгдэж байсан тодорхой нэг сэдэв, сургалтын чиглэлээр сургалтын зохион байгуулахаас илүү 2015 оны цөм хөтөлбөр нь хүүхдийн хөгжлийг цогцоор авч үзэж, хүүхэд бүрийн хөгжил адилгүй, өөрийн замаар хөгждөг гэдгийг хүлээн зөвшөөрч, хүүхэд өөрийн сонголтоор өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, тоглох үйл нь сургуулийн өмнөх боловсролын үндсэн үйл ажиллагаа болсон. Хүүхэд бүрийн хөгжлийн онцлогийг багш чанарын аргаар өдөр тутмын үйл ажиллагааны явцад тэмдэглэл хөтлөн, хүүхдийн хөгжлийн ахицын мэдээлэл дээр үндэслэн хөгжлийн түвшинд тохирсон дэмжлэгийг үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах арга зүйг сургалтын хөтөлбөрт оруулж, хэрэгжүүлснээрээ хүүхэд төвтэй сургалтын орчныг бий болгоход ахиц авчирсан.

Цаашид СӨБ-ын чанарыг сайжруулахын тулд олон улсын судлаачдын санал болгож буй хэл соёл, багш, эцэг эхийн оролцоо хамтын ажиллагаа, сургалтын орчин, боловсролын тогтолцоо (Li, Wang & Wong, 2012, p.11) зэрэг хүчин зүйлсийг манай улсын хам хүрээнд судлан тодорхойлох хэрэгцээтэй байна. Мөн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр нь соёлын хам хүрээнд нийцсэн байдал, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар чанарын судалгаа хийснээр хөтөлбөр амжилттай хэрэгжих боломжийг тодорхойлох нэг нөхцөл бий болно.

Дүгнэлт

Тус судалгаа нь Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явц, нөхцөл байдлыг чанарын судалгааны аргаар судалсан. Шинэчлэлийг ямар нэгэн олон улсын төрийн бус байгууллагын санаачилга идэвхтэй оролцоогүйгээр бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчид өөрсдөө цөм хөтөлбөрийн шинэчлэлийн хэрэгцээг олж хараад, монгол багш судлаачид санаачлан боловсруулсан. Тухай цаг үед мөн ерөнхий боловсролын болон дээд боловсролын сургалтын бусад хөтөлбөрүүд бүгд зэрэг шинэчлэгдэж, үүнтэй зэрэгцээд сургуулийн өмнөх боловсролын салбарын мэргэжилтнүүд хөгжингүй улс орны сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг биечлэн очиж туршлага судалж, үндэсний хэмжээнд хэд хэдэн удаа хэлэлцүүлэг өрнүүлэн, хөтөлбөрийг шинэчлэх гол үндэслэл болж байв. Энэ явцад олон улсын түвшинд, цаашилбал хөгжингүй улс оронд хэрэгждэг сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг өрнүүлсэн зүйл бол бага насны хүүхдийн хөгжлийг цогцоор нь авч үзэж, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжихэд тоглох үйл голлох үүрэгтэй гэдгийг сургалтын арга зүйд оруулснаараа энэхүү хөтөлбөрийн том ололт байв.

Талархал

Бидний урилгыг хүлээн авч манай судалгаанд цаг гарган ярилцлага өгсөн цөм хөтөлбөрийн багийн гишүүд болон тухайн үеийн боловсролын яаманд ажиллаж байсан ажилтан албан хаагч нарт талархал илэрхийлье.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- БНМАУ-ын Ардын Боловсролын Яам Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэн. (1986). *Сургуулийн өмнөх насны хүүхдийн хүмүүжил сургалтын программ*. Нэмэлт өөрчлөлт оруулсан хоёр дахь хэвлэл. Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар.
- БНМАУ-ын боловсролын яам. (1991). *Хүүхдийн цэцэрлэгийн хүмүүжил сургалтын хөтөлбөр*. Шинэчлэн боловсруулсан 2 дахь хэвлэл. Боловсролын яамны сурах бичиг. Хүүхдийн номын хэвлэлийн газар.
- Боловсрол шинжлэх ухааны яам (2021). *Сургуулийн өмнөх боловсрол 2020-2021 оны хичээлийн жилийн статистик мэдээлэл*. Улаанбаатар хот.
- Гэгээрлийн яам, Улсын багшийн их сургуулийн Боловсролын хөгжлийн сургууль (1999). *Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын цөм хөтөлбөр*. Улаанбаатар хот.
- Creswell, J. W., & Poth, C. N. (2016). *Qualitative inquiry and research design: Choosing among five approaches*. Sage publications. Page 84.
- Datnow, A. (2002). Can we transplant educational reform, and does it last? *Journal of Educational Change*, 3(3), 215-239. <https://doi.org/10.1023/a:1021221627854>
- Ijaduola, K.O., Odunaike, K.O., & Ajayi, V.B. (2012). The interplay between politics and education in Nigeria: any symbiotic relation? *Journal of Education and Practice* 3(9), 123-130.
- Kasuga, W. (2019). The influence of politics in curriculum change and innovation in Tanzania. *European Journal of Education Studies* 12(5). <https://doi.org/10.5281/zenodo.25959554>
- Li, H., Rao, N. & Tse, S.K. (2012). Adapting western pedagogies for Chinese literacy instruction: case studies of Hong Kong, Shenzhen, and Singapore preschools. *Early Education and Development*, 23(4), 603-621. <https://doi.org/10.1080/10409289.2010.536441>.
- Li, H., Wang, X. C., & Wong, J. M. S. (2011). Early childhood curriculum reform in China: perspectives from examining teachers' beliefs and practices in Chinese literacy teaching. *Chinese Education & Society*, 44(6), 5-23. <https://doi.org/10.2753/CED1061-1932440601>.
- Мягмар.Ж ба бусад. (2013) *Сургуулийн өмнөх боловсролын бэлтгэл бүлгийн сургалтын хөтөлбөр*. Боловсрол шинжлэх ухааны яам. Улаанбаатар: Admarket ХХК..
- Насанбаяр. Б, Норжхорлоо. Н, Нарантуяа. Ж. (2015) *Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр гарын авлага*. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам.
- Норжхорлоо. Н, Бурмаа. Ж, Гэрэлтуяа.Д, Наран.Ж, Төмөр-Очир.Д. (2014). Сингапур, Япон, Канад, Финлянд, ОХУ-ын цэцэрлэгийн сургалтын хүрээ/үндэсний хөтөлбөрийн сургуулийн өмнөх насны хүүхдэд эзэмшүүлдэг

- чадварууд (компетенц)-д хийсэн харьцуулсан судалгааны тайлан. Сургалтын стандарт, хөтөлбөр, үнэлгээний шинэчлэлийн баг. Улаанбаатар хот.
- Стандартчилал хэмжил зүйн газар. (2011). *Монгол улсын стандарт. Сургуулийн өмнөх боловсрол. Бага насны хүүхдийн хөгжил*. MNS 5420 – 1: 2011. Албан хэвлэл. Улаанбаатар хот.
- Saldana, J. (2016). *The coding manual for qualitative researchers*. Third Edition. Sage
- Vavrus, F. & Bartlett, L. (2012). Comparative pedagogies and epistemological diversity: Social and materials contexts of teaching in Tanzania. *Comparative Education Review*, 56(4), 634-658.
- World Bank. (2017). *Pre-primary education in Mongolia: access, quality of service delivery, & child development outcomes*. World Bank. <https://openknowledge.worldbank.org/handle/10986/26402>

Background of the Introduction of a Play-based Curriculum in Mongolian Preschool Education

Javzandulam Batsaikhan*

Department Methodology, School of Preschool Education,
Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

* Corresponding author:: javzandulam@msue.edu.mn

Received:4/25/2022

Revised:6/28/2022

Accepted:6/30/2022

Abstract

The purpose of the study is to explore the background of introducing a play-based curriculum in Mongolian preschool education based on the analysis of interviews with some key stakeholders. This study employed qualitative methods of document and interview analyses. First, the characteristics of the play-based curriculum were examined through the analysis of different documents, previous national preschool education curricula. Second, the author interviewed 8 key stakeholders among the 16 members of the National Curriculum Development Team (2013-2015) based on the semi-structured interview guidelines developed by the author. A timely political change then further facilitated the new curriculum development, for which the key stakeholders fully utilized their expertise and experiences, including their previous exposure to early childhood education practices in some developed nations. Among other reasons were a global awareness of the importance of competencies, Mongolian preschool teachers' claims for a better curriculum, and the key stakeholders' better understanding of the importance of play in ensuring individualized child development.

Keywords

Preschool Education, Curriculum Reform, Play Based Learning